



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/144

Бор-Өндөр сум

**“Сумын мэргэн” цол олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний их баяр наадам Монгол Тулгар төрийн 2233 жилийн ой, Их Монгол Улс байгуулагдсаны 818 жилийн ой, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтолцоо сэргээн мандуулсны 113 жилийн ой, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Хан Хэнтий Уулын аймаг байгуулагдсаны 101 жил, Бор-Өндөр сум үүсгэн байгуулагдсаны 43 жилийн ойн баяр наадмын сурын харваанд тэргүүн байр эзэлсэн Юра овогтой Буян-Өлзий-д “Сумын мэргэн” цол олгосугай.

2. Цол хүртээх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллахыг “Мянган мэргэд” сурын холбооны тэргүүн (Ө.Пүрэвжав)-д дээлгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.АДЬЯАБИЛЭГТ

